



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.УРАНЦЭЦЭГ ТАНАА

2017.02.02 № 01/02 АУА - 2017/15/СТА - ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын 2016 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Ажилтанд томилолт олгохдоо хоногийг буруу тооцож, 145,000.00 /Нэг зуун дөчин таван мянга/ төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 1996 оны 30 дугаар тушаалын хавсралт "Албан томилолтын зардал олгох заавар"-ын 8-д /Албан томилолтоор ажилласан хоногийн тоог томилолтын үнэмлэхэд тэмдэглэсэн календарийн бүх хоногоор тооцож гаргах боловч явсан, буцаж ирсэн өдрийг нэг хоногт тооцно/ заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.3-т /Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон/ заасан заалтуудыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Илүү тооцож олгосон 145,000.00 /Нэг зуун дөчин таван мянга/ төгрөгийг нягтлан бодогчоор нөхөн төлүүлж, Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 080000955 тоот дансанд 2017 оны 05 дугаар сарын 05-ны дотор төвлөрүүлэх;


Актын биелэлтийг 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Адаацаг сумын Засаг даргын тамгын газрын дарга Б.Уранцэцэг, нягтлан бодогч Б.Энхжаргал нарт хариуцуулав.

ТОГТООСОН¹:

ШИНЖЭЭЧ



Ж.УГТАХБАЯР



АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА



Б.УРАНЦЭЦЭГ

НЯГТЛАН БОДОГЧ

Б.ЭНХЖАРГАЛ



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.